# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ТОВЧОО

2024.12.09 Алтай хот

| | | |
|---|---|---|
| Хяналтад авсан арга хэмжээний тоо | | 52 |
| Үнээс | Арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрсэн /100%/ | 41 |
| | Арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан/90%/ | 7 |
| | Өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, гүйцэтгэл тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа/70%/ | 2 |
| | Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн/50%/ | 2 |
| | Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа/30%/ | |
| БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ | | 95,6 |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024.12.09 Алтай хот

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 1.1 Эрүүл мэндийн чиглэлээр | | | | | | | |
| 1.1.1 | Халдварт болон халдварт бус өвчлөлийг эрт илрүүлж, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Орон нутгийн төсөв | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын дундаж хувь | 25.2 | 28 | Чихрийн шижингийн эрт илрүүлэгт хамрагдвал зохих 22668 хүнээс 14405 буюу 63.5%, артерийн гипертензийн эрт илрүүлэгт хамрагдвал зохих 33823 хүнээс 17665 буюу 52.2% нь хамрагдаж, хамрагдалтын дундаж 58%-тай байна. хавдрын эрт илрүүлэгт 18-аас дээш насны хамрагдвал зохих 37245 хүний 46.6%-ийг хамруулаа. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт 30-аас дээш насны 3853 хүний 1385 ба 35.9%, хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 30-60 насны 11046 хүний 8251 ба 74.7%, элэгний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 40-65 насны 18646 хүний 9873 ба 52.9%, 2 жил тутам зохион байгуулагддаг ходоодны хавдрын эрт илрүүлэгт 35-аас дээш насны 21203 хүний 8731 буюу 41.1%, улаан хоолойн хавдрын эрт илрүүлэгт 35-аас дээш насны 21203 хүний 8731 буюу 41.1%, уушигны хавдрын эрт илрүүлэгт 18-аас дээш насны 37245 хүний 16203 буюу 43.5%, түрүү булчирхайн хавдрын эрт илрүүлэгт 18-аас дээш насны 18287 хүний 6512 буюу 35.6% нь хамрагдаж, элэгний 38, ходоодны 18, уушгины 5, улаан хоолойн 7, хөхний 5, бөөрний 1, умайн хүзүү 8, нойр булчирхайн 3, бүдүүн гэдэсний 7, өндгөвчний 1, тархины 3, дайвар хөндийн 1, лимфома 1, байршил тодорхойгүй хавдар 3 нийт 101 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдэн 38 буюу 37.6% нь эрт үедээ, 63 буюу 62.4% нь хожуу үедээ оношлогдлоо. Эрт илрүүлгийн үзлэгээр шинээр артерийн гипертензи 316, чихрийн шижин 69, багцын үзлэгээр ходоодны үүсгэвэр 13, бүдүүн гэдэсний үүсгэвэр 3, хөхний | 90 |
| | | | Артерын даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь | 57,7 | 58,7 | | |
| | | | Чихрийн шижин өвчний хэв шинж - 2 өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 35 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь | 69,1 | 70,1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үүсгэвэр 5 бодисын солилцооны эмгэг 233, бамбайн зангилаа 199, зүрх судасны эмгэг 37, таргалалт 233, ходоодны шарх 98, бөөр шээс ялгаруулах тогтолцооны эмгэг 53, хоол боловсруулах замын эмгэг 140, уушгины эмгэгтэй 1, ясны сийрэгжилттэй 292 хүн шинээр оношлогдсон ба нийт 3 үзлэгээр илэрсэн өвчтэй 1687 хүний 67.7% буюу 1143 хүнд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зөвлөгөө мэдээлэл өгч, эмийн эмчилгээ болон эмчийн хяналт шаардлагатай архаг хууч өвчтэй 1205 хүнийг хяналтад авч, эмчилгээнд хамрууллаа. Хөнгөвчлөх эмчилгээнд 41, мэс засалд 43, TACE буюу судас бөглөх эмчилгээнд 1, RPA буюу түлэх эмчилгээнд 2, хими-туяа эмчилгээнд 3, туяа эмчилгээнд 2, мэс засал-туяа эмчилгээнд 1, мэс засал-хими эмчилгээнд 2, хими эмчилгээнд 6 хүн хамрагдаж 100% үе шатанд тохирсон эмчилгээнд хамрагдлаа. | |
| 1.1.2 | Алтайчуудын дундаж наслалтыг нэмэгдүүлэх "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж мөрдөж ажиллана. | ОНТ | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 40 %-иас доошгүй | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн ажилтнуудад урамшуулал олгох журам боловсруулж аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ИТХ-ын 4 дүгээр сарын 25-ны өдрийн 8 дугаар тогтоолоор батлууллаа. Журмын дагуу хөдөөгийн 88 багийн Засаг дарга, багийн эмч 176 хүнд 132,0 сая төгрөг, ажил мэргэжлийн уралдаанд тэргүүлсэн сувилагч, эх, баригч, тусгай мэргэжилтэн 91 хүнд 158.0 сая төгрөгийн урамшуулал олголоо. Аймгийн хэмжээний 88 багийн Засаг дарга, багийн эмч нар 6545 өрхийн 24989 иргэний эрүүл мэндийн эрсдэлийг үнэлж, эрүүл мэндийн, нийгмийн хэрэгцээг тодорхойлох судалгаа хийлээ.Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж,түүнийг бууруулах зорилгоор хийгдэх 56 судалгааны ажлын саналыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас хүлээн авч, эрэмбэлэх хэлэлцүүлэг зохион байгуулж Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн бөгөөд одоогоор судалгаа хийгдээгүй байна. Аймгийн Засаг даргын 3 сарын А/187 дугаар захирамжаар хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг эрчимжүүлэх, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж 19 сумд ажиллаж эрүүл мэндийн төвийн 358 ажилтан, бусад байгууллагын 65 албан хаагчдад хөтөлбөрийн танилцуулга хийж мэргэжил арга зүйгээр хангаж, 2241 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийлээ.Хөтөлбөрийн танилцуулгыг нэгдсэн эмнэлгийн 195 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, аймгийн төвийн 7 байгууллагын 326 албан хаагч болон 88 багийн 6545 өрхийн 24989 иргэнд хүргэлээ.Аймгийн Засаг даргын 9 сарын А/553 дугаар захирамжаар хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлууллаа. Аймгийн Засаг даргын 11 сарын А/664 дугаар захирамжийн дагуу эрчүүдийн явуулын үзлэгийг 11 сарын 28-наас зохион байгуулж 10 сумын 433 эрчүүдийг хамруулж, 3 мэргэжлийн эмчийн 1299 үзлэг хийгдэн, "Эрчүүдийн эрүүл мэндэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох" судалгаанд хамруулаа. | |
| 1.1.3 | Хүн амын нас, хүйс, эрсдэлт хүчин зүйлд тулгуурласан багцын эрт илрүүлэг, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй, тасралтгүй зохион байгуулж улсын дунджаас 10 хувиар өсгөсөн үзүүлэлтэнд хүргэнэ. | - | Эрт илрүүлгийн хамрагдалтын дундаж хувь | 40 | 70 | Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо"-нд 2024 оны 11-р сарын 29-ний өдрийн байдлаар аймагтаа 24826, бусад газарт 4208, нийт 29034 хүн хамрагдлаа. Аймгийн хэмжээнд 58257 хүний 49,8% нь хамрагдсан нь үзлэгт хамрагдалтын улсын дундаж (46%) үзүүлэлтээс 3,8%-иар их байна. Аймагтаа үзлэгт хамрагдсан хүмүүсээс 0-17 насны 20548 хүүхдийн 65,5%, 18-аас дээш насны 37245 хүний 32,6%, 18-30 насны 11424 хүний 19,1%, 31-45 насны 12171 хүний 36,2%, 46-60 насны 9458 хүний 43,3%, 61-ээс дээш насны 4192 хүний 35,2% нь хамрагдлаа.Үзлэгийг эрчимжүүлэхээр 3-р сард аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын 7/343 тоот албан бичгээр эрт илрүүлгийн үзлэгт хамрагдаагүй төрийн албан хаагчийн судалгаа хийж, албан хаагчдыг үзлэгт хамрагдах хуваарь гарган хүргүүлж, Засаг даргын Тамгын газрын даргын 6 дугаар сарын 5-ны өдрийн 3/727 дугаар албан бичгээр хамрагдаагүй төрийн албан хаагчдыг үзлэгт хамруулахыг, Засаг даргын Тамгын газрын даргын 6 дугаар сарын 13-ны өдрийн 3/771 албан бичгээр үзлэгт хамрагдаагүй төрийн албан хаагч, харьяаллын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүн амыг үзлэгт хамруулах тухай сумдын засаг дарга, байгууллагын дарга нарт хүргүүллээ.Үзлэгийн ач холбогдлын талаар 6 байгууллагын 379 албан хаагч, иргэнд "Говь-Алтай 80+" хөтөлбөрийг танилцуулах аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг 17 сум, 2 тосгоны 1947 иргэнд, ЕБС-ийн захиарал 29, ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 68, Алтай орон сууцны корпорацийн 12, эрчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн үеэр 2 сумын 89, нийт 2415 хүнд зөвлөгөө мэдээлэл хүргэж, үзлэгийн ач холбогдол, дэмжих төвийн үйл ажиллагаа, эрт илрүүлгийн үзлэгээр илэрч байгаа хавдрын өвчлөл, дурангийн шинжилгээ хийлгэхэд анхаарах асуудлын талаар орон нутгийн радиод 4, МонЦаМэ агентлагт 1, Алтай телевизээр 4 нийт 8 удаа нэвтрүүлж, байгууллагын цахим хуудсаар 41 төрлийн мэдээлэл байршуулан үзлэгт хамрагдахыг уриаллаа. | |
| 1.1.4 | Аймгийн нэгдсэн эмнэлэг ,сум дундын эмнэлгүүдэд мэргэжлээс шалтгаалсан өвчний үзлэг хийх, сэргээн засах кабинет ажиллуулна. | ОНТ | Хэрэгжилтийн хувь | - | 90 | Мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах зорилгоор тоосжилт өвчнийг үүсгэх эрсдэлтэй уул уурхайд ажилладаг 723 ажилтны судалгааг гарган МСЭМХ-д хүргүүлж, судалгааг үндэслэн урьдчилан сэргийлэх үзлэгийг 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн боловч санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй тул үзлэг зохион байгуулагдаагүй. Нэгдсэн эмнэлгийн сэргээн засахын кабинетээр 3995 хүн үйлчлүүллээ. Эдгэрэх боломжтой эрүүлжүүлсэн хүний тоо 3390 байна. | 70 |
| 1.1.5 | Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл шүд" арга хэмжээний хүрээнд сумын эрүүл мэндийн төвд амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн амны хөндийн үзлэг | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 50-иас доошгүй | 90-иас доошгүй | Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо"-нд 2024 оны 11-р сарын 29-ний өдрийн байдлаар аймагтаа 24826, бусад газарт 4208, нийт 29034 хүн хамрагдлаа. Аймгийн хэмжээнд 58257 хүний 49,8% нь хамрагдсан нь үзлэгт хамрагдалтын улсын дундаж (46%) үзүүлэлтээс 3,8%-иар их байна. Аймагтаа үзлэгт хамрагдсан хүмүүсээс 0-17 насны 20548 хүүхдийн 65,5%, 18-аас дээш насны 37245 хүний 32,6%, 18-30 насны 11424 хүний 19,1%, 31-45 насны 12171 хүний 36,2%, 46-60 насны 9458 хүний 43,3%, 61-ээс дээш насны 4192 хүний 35,2% нь хамрагдлаа.Үзлэгийг | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оношилгоо, эмчилгээний явуулын баг ажиллуулна. | | | | | эрчимжүүлэхээр 3-р сард аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын 7/343 тоот албан бичгээр эрт илрүүлгийн үзлэгт хамрагдаагүй төрийн албан хаагчийн судалгааг хийж, албан хаагчдыг үзлэгт хамрагдах хуваарь гарган хүргүүлж, Засаг даргын Тамгын газрын даргын 6 дугаар сарын 5-ны өдрийн 3/727 дугаар албан бичгээр хамрагдаагүй төрийн албан хаагчдыг үзлэгт хамруулахыг, Засаг даргын Тамгын газрын даргын 6 дугаар сарын 13-ны өдрийн 3/771 албан бичгээр үзлэгт хамрагдаагүй төрийн албан хаагч, харьяаллын хүн амыг үзлэгт хамруулах тухай сумдын засаг дарга, байгууллагын дарга нарт хүргүүллээ.Үзлэгийн ач холбогдлын талаар 6 байгууллагын 379 албан хаагч, иргэнд "Говь-Алтай 80+" хөтөлбөрийг танилцуулах аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг 17 сум, 2 тосгоны 1947 иргэнд, ЕБС-ийн захиарал 29, ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 68, Алтай орон сууцны корпорацийн 12, эрчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн үеэр 2 сумын 89 нийт 2415 хүнд зөвлөгөө мэдээлэл хүргэж, үзлэгийн ач холбогдол, дэмжих төвийн үйл ажиллагаа, эрт илрүүлгийн үзлэгээр илэрч байгаа хавдрын өвчлөл, дурангийн шинжилгээ хийлгэхэд анхаарах асуудлын талаар орон нутгийн радиод 4, МонЦаМэ агентлагт 1, Алтай телевизээр 4 нийт 8 удаа нэвтрүүлж, байгууллагын цахим хуудсаар 41 төрлийн мэдээлэл байршуулан үзлэгт хамрагдахыг уриаллаа. | |
| 1.1.6 | Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллана. | - | Гэрээний хэрэгжилтийн хувь | 80 | 90 | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/122 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг дарга, ЭМГ-ын дарга, Жаргалан-Алтай, Марал-Алтай, Энх-Алтай өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай 2024 оны 04 сарын 01-ний өдөр өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээг шинэчлэн байгуулж, хагас жилийн биелэлтийг Аймгийн Засаг даргын 2024 оны А/285 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг үнэллэлээ.<br>Үнэлгээг гэрээний шалгуур үзүүлэлтүүдийн дагуу 5 бүлэг бүхий 53 заалтаар үнэлхэд Жаргалан-Алтай 90,3%, Марал-Алтай 85,0%, Энх-Алтай 90,0%-тай тус тус үнэлэгдлээ. Өрхийн эрүүл мэндийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төвүүдийн гэрээний хагас жилийн дундаж хэрэгжилт 88.4%-тай байна. Жилийн эцсийн үнэлгээг 2025.01.15-ны дотор хийхээр төлөвлөгдсөн | |
| 1.1.7 | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр орон сууц, гэрээр хангах, малжуулах арга хэмжээ хэрэгжүүлнэ. | ОНТ | Хамрагдсан албан хаагчийн то | 80 | 100 | "Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөө"-г 4 зорилтын хүрээнд 13 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд биелэлт 97.6%-тай байна. Дараах томоохон арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ. Үүнд: Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд эрүүл мэндийн ажилтны "Түрээсийн орон сууц"-ны хөтөлбөрт хамруулахад дэмжлэг үзүүлэхэд 880,0 сая төгрөгийг батлуулж 4 улиралд олгохоор төлөвлөж байна. Шарга сумын Эрүүл мэндийн төв 2, Тайшир сумын Эрүүл мэндийн төв 1, Бугат сумын Эрүүл мэндийн төв 2, Халиун сумын Эрүүл мэндийн төв 1, Дарив сумын Эрүүл мэндийн төв 1 нийт 5 эрүүл мэндийн төв нь 7 эрүүл мэндийн ажилтныг орон байраар хангах боломжийг бүрдүүлсэн бөгөөд Шарга, Бугат, Халиун, Дарив сумын Эрүүл мэндийн төвүүдэд ажиллахаар очсон 5 эрүүл мэндийн ажилтныг тус бүр үнэ, төлбөргүй байраар хангаад байна. Мөн өвөлжилт, хаваржилт хүндэрсэн сумуудад Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн А/14 дугаар тушаалаар Тонхил 2, Халиун 1, Шарга 1, Тайшир 1, Цогт 1, Эрдэнэ 2 нийт 6 эрүүл мэндийн төвд хуваарилагдан ажилласан 8 резидент эмч нарыг тус бүр үнэ, төлбөргүй байраар хангаж 1 сар 15 хоног ажиллууллаа. Харьяа 24 байгууллагын 871 эрүүл мэндийн ажилтанд 13533,2 сая төгрөгийн цалин, 867 эрүүл мэндийн ажилтанд 701,4 сая төгрөгийн хоолны мөнгө, 784 эрүүл мэндийн ажилтанд 722,1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 478 эрүүл мэндийн ажилтанд 587,8 сая төгрөгийн илүү цагийн хөлс, 353 эрүүл мэндийн ажилтанд 329,9 сая төгрөгийн зэрэг дэвийн нэмэгдэл, 338 эрүүл мэндийн ажилтанд 182,3 сая төгрөгийн бичиг хэргийн материал, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, 12 байгууллага 465 эрүүл мэндийн ажилтанг урьдчилан сэргийлэх үзлэг, витаминжуулалтад хамруулахад 14,5 сая төгрөгийг зарцууллаа. Аймгийн ИТХ-ын 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | журмын дагуу 6545 өрхийн 24989 иргэний эрүүл мэндийн эрсдэлийг үнэлж, эрүүл мэндийн болон нийгмийн хэрэгцээг тодорхойлох судалгаагаар хийлгэж багийн Засаг дарга, багийн эмч, өрхийн эмч нийт 176 хүнд 132,0 сая төгрөг, ажил мэргэжлийн уралдаанд тэргүүлсэн 91 сувилагч, эх, баригч, тусгай мэргэжилтний ур чадварыг үнэлж 158,0 сая төгрөгийн урамшуулал олголоо. Эрүүл мэндийн ажилчдад улсын төсвөөс 16071,1 сая төгрөг , орон нутгийн төсвөөс 290 сая төгрөг, нийт 16361,2 сая төгрөгийг зарцууллаа | |
| 1.1.8 | Орон нутгийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулна. | ОНТ | Арга хэмжээний тоо | - | 2 | Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар дамжуулан "Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлье" "Осол гэмтлээс сэргийлэх нь" сэдвийн хүрээнд 47 удаа 11 төрлийн зурагт хуудас, байршуулан мэдээлэл хүргэж 8457 хүний хандалт авлаа. | 90 |
| 1.1.9 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн тусламж , үйлчилгээг авах дэд бүтцийг эрүүл мэндийн байгууллагуудад бүрдүүлж ажиллана. | ОНТ | Эрүүл мэндийн байгууллагын тоо | 8 | 23 | Эрүүл мэндийн байгууллагууд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ээлтэй хүртээмжтэй хүргэх зорилгоор 15 эрүүл мэндийн байгууллага стандартын налуу зам 5 байгууллага стандартын ариун цэврийн өрөө, 14 байгууллага тод гэрэлтүүлэг, хана дагасан бариул, машины тусгай зогсоолыг хийсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахад саадгүй хүртээмжтэй байх үүднээс 5 эрүүл мэндийн байгууллагууд амбулаторид дохионы хэл болон брайл үсгийн цагаан толгой, 12 эрүүл мэндийн байгууллага дуугүй хөтөч, үйлчлүүлэгчийг зөв таних тэмдэглэгээнүүдийг хийлээ. Мөн Эрүүл мэндийн байгууллагуудад харааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчид зориулан брайл үсгээр өрөөний хаяг, эрүүл мэндийн үзлэгийн анхан шатны асуумжийг хийж гүйцэтгэхээр хэвлэлтэд өгөн ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагууд дохионы хэлний сургалтад ажилтан албан хаагчдаа сургахаар төлөвлөн ажиллаж байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аймгийн хэмжээнд 15 эрүүл мэндийн төв төвлөрсөн халаалтын шугамд холбогдож, Алтай, Бигэр сумын эрүүл мэндийн төвүүд төвлөрсөн халаалтын шугамд холбогдох үйл ажиллагаа явагдаж байна. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн улсын үзлэгийг орон нутагт зохион байгуулах ажлыг Аймгийн төвийн 25 ба түнээс дээш ажилтантай 48 байгууллага, аж ахуйн нэгж, Чандмань, Эрдэнэ, Цогт, Баянтоорой, Дэлгэр, Гуулин, Тайшир, Жаргалан, Баян-Уул, Хөхморьт, Шарга, Төгрөг, Бугат, Алтай, Цээл сумдын төсвийн тус бүр 5 байгууллага, ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв болон дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, ШТС нийт 119 аж ахуйн нэгж, байгууллагад улсын үзлэг хийж, бодит нөхцөл байдлыг газар дээр нь үзэж шалгахад хөгжлийн бэрхшээлтэй иргэний саадгүй нэвтрэх орц, гарц, бусад тоноглолоор нэвтрэх тоноглолыг 66% нь хийгээгүй байгаа нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчиж байна. Дээрх зөрчлийг засаж сайжруулахаар холбогдох байгууллагуудад улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлээ. | |
| 1.1.10 | Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт хийх | Онт | Зөрчил арилгуулалтын хувь | 58 | 65 | Эрүүл мэндийн яам, Хүнс хөдөө аж ахуйн яамны салбарын ерөнхий байцаагчдын хамтран баталсан 08-00-02/03 дугаар удирдамжийн дагуу аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран цагаан сарын баяр, хүүхдийн баяр, наадам, Бурхан буудайн тахилгын үеэр худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй 253 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалтыг хийж гүйцэтгэв. Хяналтын явцад лаборатори шинжилгээнд 27 хүнсний бүтээгдэхүүн хамруулан, 11 заалттай 3 төрлийн зөвлөмж тараав. | 100 |
| **1.2. Биеийн тамир, спортын чиглэлээр** | | | | | | | |
| 1.2.1 | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор | ОНТ | Хэрэгжилтийн хувь | 90 | 100 | Ахмадуудад 7 хоногт 2 удаа 8 цагийг Биеийн тамир, спортын газрын заалыг үнэ төлбөргүй ашиглуулж давхардсан тоогоор 1356 ахмадууд өөрийн эрүүл мэнддээ анхаарч идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хичээллэхэд нь дэмжлэг үзүүлэх биеийн тамир, спортын барилга байгууламж, талбайг үнэ төлбөргүй ашиглуулах, хүртээмжтэй болгох, клубын үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлж ажиллана. | | | | | зорилгоор дасгал хөдөлгөөн хийж байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд уралдаан тэмцээнд оролцох үеэр бэлтгэл хийх боломжоор хангаж, мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллаж байна.<br>Мөн "Залуур Алтай төв"-д байрлах бужгийн клуб-д ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ идэвхтэй хамруулах талаар хамтран ажиллаж 2024 оны ОНОТХҮ-ний бүлгийн төслөөс 3000,0 мянган төгрөгийн төслийн санхүүжилт тус бүлэгт олгож, үйл ажиллагаа нь өргөжлөө. | |
| 1.2.2 | Өсвөр үеийн шигшээ багийг 8 (найм)-аас доошгүй төрлөөр байгуулж, тамирчдын бэлтгэлийг хангаж наадам, тэмцээнд оролцуулах, амжилтыг нэмэгдүүлэх болон бусад үйл ажиллагааг зохион байгуулах зардлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. | ОНТ | Тамирчны тоо | 8 төрөл 124 тамирчин | 8 төрөл 150 тамирчин | Аймгийн засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг дэмжих "Аваргыг аймагтаа" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг спортын 8 төрлөөр / волейбол, сагсан бөмбөг, жудо, чөлөөт бөх, шатар, хөл бөмбөг, хөнгөн атлетик, таеквондо / нийт 240 гаруй өсвөр үеийн тамирчид бэлтгэгдэж байна. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 16 төрлөөр / волейбол, сагсан бөмбөг 5х5, сагсан бөмбөг 3х3, ширээний теннис, шатар, даам, таеквондо, хөл бөмбөг, жудо, чөлөөт бөх, самбо бөх, миний волейбол, сагсан бөмбөг бага нас, хөнгөн атлетик, үндэсний бөх, сумо бөх / 2024 оны 03 дугаар сарын 09-15 өдрүүд болон 04 дүгээр сарын 21-25 өдрүүдэд зохион байгуулж 18 сум 2 тосгон аймгийн төвийн 5 сургуулийн 1670 тамирчин 684 багц медалийн төлөө өрсөлдөж улсын төсвөөс 25.429.900 төгрөг зарцууллаа.<br>Өсвөр үе, идэрчүүдийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээн спортын 5 төрлөөр / волейбол, ширээний теннис, жудо, чөлөөт бөх, хөл бөмбөг / Увс, Ховд, Говь-Алтай аймгуудад зохион байгуулагдаж алт – 23, мөнгө – 24 хүрэл – 41 медаль хүртэж улсын төсвөөс 25.992.800 төгрөг зарцууллаа.<br>Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн спортын 9 төрлөөр / Сагсан бөмбөг, волейбол, жудо, самбо, чөлөөт бөх, хөл бөмбөг, шатар, даам, ширээний теннис, үндэсний бөх / зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулагдаж алт-6, мөнгө- 16, хүрэл-18 медаль хүртэж улсын төсвөөс 39.039.200 төгрөгийг зарцуулаа. Мөн Биеийн тамир спортын улсын хороо, Үндэсний шигшээ багийн алба, Спорт ангаах ухаан, эрдэм шинжилгээний төвтэй хамтран тус төвийн эрдэм шинжилгээний ажилтан, ангаах ухааны их эмч нийт 6 албаны хүн Говь-Алтай аймагт ажиллаж "Өсвөр үеийн тамирчдын ажиллах чадварын цогц сорил шинжилгээ" судалгааны ажлыг 2024 оны 12 дугаар сарын 2-ны өдөр зохион байгуулж спортын 6 төрлийн / волейбол, сагсан бөмбөг, хөл бөмбөг, жүдо, хөнгөн атлетик / 57 хүүхэд хамрагдлаа. | |
| 1.2.3 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж иргэдийг хамруулах, шинэ тоголцоог бий болгоход хамтран ажиллана. | ОНТ | БТАХ хамрагдагчдын тоо Спортоор хичээллэгчдийн тоо | БТАХ хамрагдагчдын тоо-1859 Спортоор хичээллэгчдийн тоо - 1172 | 3000<br>1500 | Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53-р тоот зарлиг, Говь-Алтай 80+ хөтөлбөрийн хэрэгжилтийн хангах ажлын хүрээнд "Хүн амын бие бялдар чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил"-ыг 3 үе шаттай зохион байгуулж явууллаа. 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд төрийн албан хаагчдаас асуумж судалгаа сорил авах ажлыг зохион байгуулж 9 сум аймгийн төвийн 23 төрийг байгууллагын 482 албан хаагчид хамрагдлаа. 04 сарын 10-ны өдрөөс 05 сарын 10 мөн 10 дугаар сарын 10-наас 11 дүгээр сарын 10 хооронд сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас сорил авч ажиллалаа.<br>3-5 насны-1078,<br>6-8 нас – 30,<br>9-11 нас – 145,<br>12-17 нас – 744,<br>18-64 нас-1506 нийт 3503 иргэдийг хамрууллаа. | 100 |
| 1.2.4 | "Иргэдийн спортын наадам-2024" арга хэмжээг зохион байгуулна. | ОНТ | Хамрагдах хүний тоо | 1985 | 2500 | Иргэдийн бие бялдрыг дээшлүүлэх спортын тэмцээн уралдаанд татан оролцуулах хөдөлгөөнөөр дамжуулан эрүүл мэндийг бэхжүүлэх зорилгоор "ИРГЭДИЙН СПОРТЫН НААДАМ"-2024 спортын 6 төрлөөр /волейбол, сагсан бөмбөг 3х3, дартс, олс таталт, ширээний теннис, даам/ Алтай хотын хэмжээнд зохион байгуулж 24 байгууллага, 5 багийн 754 тамирчин оролцож өрсөлдлөө. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.3. Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр** | | | | | | | |
| 1.3.1 | "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | ОНТ | Арга хэмжээний тоо | 2 | 3 | "Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөрийн хүрээнд 1012 оюутанд 324,0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг, 68 багшид 191,0 сая төгрөгийн урамшуулал, сургалт, олимпиад зохион байгуулах зардалд 83.5 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 58,5 сая нийт 657,0 сая төгрөгийг зарцуулсан. 2024 оны 05 сарын 31-ний ИТХ хурлаар 2024 оны Анги олимпиад, ур чадварын уралдаанд амжилт гаргасан багш, сурагчид болон бэлтгэсэн багш, соёл урлаг, спортын чиглэлээр амжилт гаргасан сурагчдад олгох урамшуулалд 2,2 тэрбум төгрөг батлуулан ажиллалаа. Мөн элсэлтийн шалгалтад амжилт гаргасан багш нарт 400,0 сая төгрөгийн урамшуулал олгохоор ИТХ-р хэлэлцүүлэн тогтоол гарсан 2024 онд Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд ЕБС, СӨБ-н 1033 багшид 2,398.0 сая төгрөг, 135 сурагчид 200.0 сая, 12 сургуульд 35.0 сая, 8 сумд 31.0 сая, 536 оюутанд 383.9 сая төгрөгийн урамшуулал олгож Мэргэжилийн боловсролын сургуулийн 50 багшийг 99.9 сая төгрөгөөр компьютержүүлэн, 13 төрлийн сургалтыг 73.2 сая төгрөг, 4 цэцэрлэг, 1 сургуулийн сургалтын орчин сайжруулахад 140,4 сая төгрөг зарцуулан нийт 3,556.4 сая төгрөгийн төсөв батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. | 100 |
| 1.3.2 | Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг зохион байгуулна. | ОНТ | Арга хэмжээний тоо | 1 | - | Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын даваа 2024 оны 1 дүгээр сарын 24-17-ны өдрүүдэд зохион байгууллаа. Нийт 15 судлагдахууны 54 ангиллын олимпиадад 260 багш, 480 сурагч амжилттай оролцлоо. Олимпиадын хичээл бүрийн эхний 3 байрын 48 багшид 13,6 сая төгрөг, 99 сурагчид 14,9 сая төгрөг нийт 37,0 сая төгрөгийн шагналыг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-өөс санхүүжүүллээ. | 100 |
| 1.3.3 | Аймгийн хэмжээнд үндэсний хэл, бичиг үсгээ сурч судлах, эзэмших, хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах | ОНТ | Үйл ажиллагааны тоо | 1 | 1 | 2024.01.19-нд монгол хэлний багш нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. ХБСЗ-н жилийн төлөвлөгөө хийж батлуулан сумдын зөвлөлүүдэд танилцуулж чиглүүлэг өгсөн. Төрийн байгууллагуудын гадна хаягжилт 100 хувь хийгдсэн бол хувийн хэвшлийн байгууллагуудын хаягжилт 70 хувьтай байна. Монгол бичгийн дунд, ахлах ангийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж, албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр бүх түвшинд хэрэгжүүлнэ. | | | | | зөв шударга уншлагын олимпиад 2 үе шаттай зохион байгуулсан. Үүнд 47 сурагч оролцож шилдэг 10 сурагч улсад оролцох эрхээ авлаа. Мөн Монгол хэл, бичгийн олимпиадад 112 багш, 98 сурагч хамрагдаж шалгарсан багш нарыг шагнаж урамшууллаа.<br><br>Анги нийтийн сорилго 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 04-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан. Монгол хэлний сорилгод 9 дүгээр ангийн 25 анги бүлгийн 512 сурагч хамрагдаж 64,2 хувийн дундаж гүйцэтгэлтэй байлаа.<br><br>Монгол бичгийн Улсын XVIII олимпиадын анги /баг/-ийн төрөлд 9,12 дугаар ангиудын дунд зохион байгуулагдлаа. Тус олимпиадын хоёрын давaанд 9 дүгээр ангид 17 сургуулийн 18 бүлэг, 12 дугаар ангид 9 сургуулийн 9 бүлэг, нийт 640 сурагчийн материал ирснээс шилдэг 6 бүлэг 3 дугаар шатны шалгаруулалтад оролцохоор шалгарсан байна. Төрийн байгууллагуудын дунд монгол бичгийн "Үндэсний бичгээ өвлөн бахархъя" уралдаан номын сантай хамтран зохион байгуулж, 12 байгууллагын 36 албан хаагч оролцлоо. | |
| 1.3.4 | "Багш- Эрдэнэ" арга хэмжээг Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран зохион байгуулна. | ОНТ | Арга хэмжээний тоо | 1 | 1 | 2024 оны 09 сарын 08-ны өдөр Алтай хотноо "БАГШ-ЭРДЭНЭ" 1000 багшийн чуулган амжилттай зохион байгуулагдлаа.<br>Алтай нутгийнхаа өнцөг булан бүрт эрдмийн үрийг тарьж яваа 1000 орчим эрдэмтэн багш нар 8 судлагдахууны багт хуваагдан цахимаар салбар хуралдааныг зохион байгуулж, салбар хуралдаанаас гарсан санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж "УРИАЛГА" гаргалаа.<br>Санал дүгнэлтийг дараах чиглэлийн хүрээнд хэлэлцлээ. Үүнд:<br>1. "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн үр дүн, асуудал, шийдэл<br>2. Багшийн хөгжил, нийгмийн баталгаа, мэргэжлийн нэр хүнд, үнэ цэн<br>3. Сургалтын чанар, хөтөлбөрийн хэрэгжилт<br>4. Хүүхдийн хөгжил, хамгаалал<br>Мөн "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн шагнал урамшуулал олгох журмын хүрээнд ЭЕШ болон улсын олимпиад, бусад уралдаанд амжилт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзүүлсэн багш нарын төлөөлөлд шагнал гардуулж, салбарын тэргүүлэх арга туршлагатай багш нарын төлөөллөөр "САЙН ТУРШЛАГА"-ыг нь хэлэлцүүллээ. Мөн тус чуулганаар "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн шагнал урамшуулал олгох журмын хүрээнд ЭЕШ болон улсын олимпиад, бусад уралдаанд амжилт үзүүлсэн багш нарын төлөөлөлд шагнал гардууллаа. | |
| 1.3.5 | Орон нутагт шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх асуудлаар хууль тогтоомжинд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, шинэ санал, санаачлагыг дэмжин хамтран ажиллана. | ОНТ | Тоо | 1 | 1 | Сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсролын үйлчилгээг салбарын хууль, тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Боловсролын ерөнхий хууль болон шинээр батлагдан гарсан хууль, тогтоомжийг Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтнүүд аймгийн төвийн ерөнхий боловсролын 5 сургуулийн 235 ажилтан, албан хаагчдад 2024 оны 3 сарын 31, 4 сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулж ажиллалаа.<br>Аймаг, орон нутагт шинжлэх ухаан, инноваци, технологийг хөгжүүлэх 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр саналыг хүргүүлж ажиллалаа. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Мобиком компанийн "smart education-4" төслийн санхүүжилтээр ерөнхий боловсролын IV сургуульд ухаалаг анги, БНСУ-ын хөрөнгө оруулалтаар нэгдүгээр сургуульд мэдээлэлзүйн ухаалаг танхимуудыг байгуулав.<br>Боловсролын яам, Аймгийн боловсролын газар, БНСУ-ын Дэжон хотын Боловсролын газар хамтран 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Есөнбулаг сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуульд компьютер, мэдээлэлзүйн ухаалаг танхимыг шинээр тохижуууллаа. Боловсролын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Юнител групп хамтран "Дэлхийн сансрын долоо хоног" арга хэмжээг 2024 оны 10 сарын 04-10-ны хооронд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиуд болон мэргэжлийн боловсролын сургуулийн 12975 суралцагч хамрагдлаа. С.Янжингийн нэрэмжит эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн дундах "Ур чадварын тэмцээн"-ийг III өртөөгөөр зохион байгууллаа. Нийт 16 эм найруулагч тэмцээнд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцсон бөгөөд 3 өртөөний дундаж дүнгээр 3 байр шалгарууллаа.<br>Боловсролын түншлэл-хөгжлийн гарц хичээлийн жилийн зорилго зорилтын хүрээнд 'Хан -Алтай " ХХК аас санхүүгийн дэмжлэг авч МУИС одон орон судлалын тэнхимийн хамтран "Шинжлэх ухаанч хүүхэд " хөтөлбөр хэрэгжүүлж 28 сургуульд одон орон судлалын дуран авиаг худалдан авч өгөхөөр санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. | |
| **1.4. Соёл, урлагын чиглэлээр** | | | | | | | |
| 1.4.1 | Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна | ОНТ | Дэмжлэг үзүүлсэн албан хаагчийн тоо | 10 | 25 | Соёлын салбарын бодлого, төлөвлөлтийн уялдааг хангах, соёлын өвийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулахад анхаарах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, иргэд олон нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх зорилготой "Алтайн соёлын сэргэлт 2024" аймгийн соёл, урлагийн салбарын албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг 2024 оны 01 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газар, Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагатай хамтран зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймгийн Соёл, урлагийн газар, Ардын дуу бүжгийн "Алтай" чуулга, "Жангар" номын сан, "Жангар" музей, 17 сум, 2 тосгоны Соёлын төвийн нийт 156 албан хаагч хамрагдлаа. Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/111 тоот захирамжаар соёлын салбарт нэн түрүүнд шаардлагатай байгаа мэргэжлээр мэргэжил дээшлүүлэх 20 албан хаагч тус бүр 2 сая, нийт 40 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | 100 |
| 1.4.2 | "Соёлын сэргэлт-2024" арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж оролцоно. | | Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо | - | Орон нутгийн оролцоог хангаж оролцсон байна | Соёлын сэргэлт-2024 аяны хүрээнд Соёл, урлагийн салбарын удирдах ажилтны улсын зөвлөгөөн 2024 оны 05 дугаар сарын 06,07-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, тус аймгийн АДБ-ийн Алтай чуулга, аймгийн Музей, 17 сум 2 тосгоны соёлын төвийн дарга нар болон Соёл, урлагийн газрын дарга болон хэлтсийн дарга нар оролцлоо. Тус зөвлөгөөнөөр "Соёлын салбарын бодлого, хэрэгжилт" сэдэвт илтгэлийг салбарын сайд танилцуулж, бүсчилсэн хэлэлцүүлэгээр "Бүс нутгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нөөц боломж, соёлын байгууллагуудын хамтын ажиллагаа" сэдвээр хэлэлцлээ.<br>Мөн "Соёлын бүтээлч сар-2024" аяны хүрээнд Говь-Алтай аймгийн Соёл, урлагийн газар, АДБАлтай чуулга, Жангар музей, Жангар нийтийн номын сан, 17 сум, 2 тосгон соёлын төв соёлын өв, урлаг уран бүтээл, соён гэгээрлийн чиглэлээр давхардсан тоогоор 105 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 25778 хүнд аяныг сурталчлан, соёл, урлагийн үйлчилгээ үзүүлэн ажиллаа. | |
| 1.4.3 | "Авьяаслаг Алтайчууд" арга хэмжээг АДБАЧ-тай хамтран зохион байгуулна | ОНТ | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 1 | Алтай нутгийн ард иргэдийн урлагт хандах хандлага, төлөвшил, оюуны сэтгэлгээний бүтээлч байдал, авьяас чадварыг нээн илрүүлэх, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг тодруулах, алдаршуулах, нэмэгдүүлэх, урлагийн язгуур шинж болон орчин цагийн хэлбэрийг дэлгэрүүлэх зорилгоор "Авьяаслаг Алтайчууд" арга хэмжээг зохион байгуулахаар төсөл, хөтөлбөр, удирдамжийг 2024 оны 02 сарын 16-ны өдөр батлуулсан бөгөөд 3 үе шаттайгаар зохион байгуулж гала тоглолтыг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгууллаа. | 100 |
| 1.4.4 | Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого зохион байгуулна. | ОНТ | Тооллогын тайлан | 2018 оны тайлан | Хууль тогтоомжийн дагуу тайланг хийж ирүүлсэн байна. | Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам", Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Соёлын сайдын 2023 оны "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай" А/317 дугаар тушаалын дагуу тооллогын ажил зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/670 дугаар захирамжаар байгуулан бэлтгэл, суурь судалгааны ажлыг шинэчлэн ажиллаж байна. Тооллого Улсын хэмжээнд 8 сард зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн боловч, салбарын яамнаас чиглэл ирээгүй тул энэ ажил хийгдээгүй болно. | 50 |
| 1.4.5 | "Алтайн соёлын сэргэлт" арга хэмжээг зохион байгуулна. | ОНТ | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 1 | "Соёлын бүтээлч сар-2024" аяны хүрээнд Говь-Алтай аймгийн Соёл, урлагийн газар, АДБАлтай чуулга, Жангар музей, Жангар нийтийн номын сан, 17 сум, 2 тосгон соёлын төв соёлын өв, урлаг уран бүтээл, соён гэгээрлийн чиглэлээр давхардсан тоогоор 105 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 25778 хүнд аяныг сурталчлан, соёл, урлагийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээ үзүүлэн ажиллаа. | |
| 1.4.6 | "Аймгийн цагаан сарын золголтын нэвтрүүлэг" хийнэ. | ОНТ | Нэвтрүүлгийн тоо | - | 1 | ТВ8 телевизтэй гэрээ байгуулан "Амар байна уу Алтай" 60 минутын цагаан сарын нэвтрүүлгийг бэлтгэн 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 11-ны өдрүүдэд өргөн нэвтрүүлгийн ТВ8 телевизээр болон тус телевизийн цахим хуудсаар цацлаа. Мөн тухайн нэвтрүүлгийг хүлээн авч архивын нэгж үүсгэлээ. | 100 |
| 1.4.7 | Уламжлалт өв соёлыг тээгчид ардын авьяастнуудыг дэмжих, сурталчлах, бүтээл урлалыг өвлөн уламжлах, нийтийн хүртээл болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулна. | ОНТ | Хэрэгжилтийн хувь | - | 100 | Монгол үндэсний соёлын өвийг олон нийтэд сурталчлан таниулах, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, өвлөн уламжлагч нарыг алдаршуулан сурталчлах, хойч үедээ үлгэр дууриайлал, манлайлал бий болгох зорилготой Соёлын өвийн үндэсний төв, Монголын Үндэсний олон нийтийн телевиз хамтран зохион байгуулсан "Монгол түмний мэнд" сар шинийн нэвтрүүлэгт, өвлөн уламжлагч гар урлаач Я.Чойжин, Г,Золзаяа, хөгжимчин Р.Ариунаа, Н.Жанчивдорж нар оролцож, замын зардалд 608,000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ.<br>"Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс 18-ны өдрийн хооронд зохион байгуулагдаж, тус аймгаас нийт 36 уламжлалт өв соёлыг өвлөн уламжлагч, ардын авьяастнуудыг оролцоход зохион байгуулалтын болон санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Тус наадамд оролцоход нийт 38.0 сая төгрөгийн төсөв зарцуулагдсан бөгөөд үүнээс 20.0 сая төгрөгийг Улсын төсөв, 18.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцууллаа. | 100 |
| 1.4.8 | 33 дахь удаагийн номын баярыг зохион байгуулна. | ОНТ | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | "Илүү их уншъя" уриатай 35 дахь удаагийн номын баяр "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024" арга хэмжээ 05 сарын 17-ны өдөр ХГБЗХГ-ын "Мазаалай" театрт зохион байгуулагдлаа. Номын баярын үеэр "Урнаар уншихуй" уншигч зохиолчдын уулзалт, "Хараат заяа" шүлгийн клубын сурагчдын дунд шүлгийн уралдаан, "Шидэт урлал" номтой холбоотой бүтээлч үйлдвэрлэлийн уралдаан, сургуулийн өмнөх насны хүүхэд багачуудын дунд "Үлгэрийн баатруудыг хэн сайн амилуулсан бэ?" дүрийн тоглолт, "Үлгэрээс үлгэрлэе" чанга уншлагын уралдаан, айл өрх, албан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагуудын дунд "Номтой зочин" цуврал контент тус тус зохион байгуулагдлаа. "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024" арга хэмжээнд давхардсан тоогоор 1100 гаруй иргэд, хүүхэд багачууд хамрагдлаа. | |
| 1.4.9 | "Туулсын хаан Жангар" арга хэмжээг зохион байгуулна. | ОНТ | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Тууль хайлах арга хэмжээг соёлын брэнд үйлчилгээ болгон хөгжүүлж удиртгал, 17 бүлгийг 1350 хүний бүрэлдэхүүнтэй хайлж буй "Алтайн Жангарчид" бүтээлээр Монгол улсын оюуны өмчийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн А/25 дугаар тушаалаар зохиогчийн эрхийн гэрчилгээ авлаа. "Туульсын хаан жангар" арга хэмжээг 20224 оны 12 дугаар сарын 21/22-ны өдрүүдэд Алтай хотод зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 100 |
| 1.4.10 | Ховд аймагт зохион байгуулагдах баруун бүсийн "Мөнгөлөг шагшуурга" мөсний баярын арга хэмжээнд аймгийн мэргэжлийн уран бүтээлчдийн баг оролцуулж, шилдэг бүтээлүүдээ толилуулна. | ОНТ | Хэрэгжилтийн хувь | - | 100 | Баруун Монгол түмний угсаатны соёлын онцлогийг таниулж, Үндэсний өв соёлоороо бахархах, үзэсгэлэнт байгаль дэлхийгээ хайрлаж хамгаалах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой "Мөнгөлөг шагшуурга-2024" мөсний баяр 01 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд Ховд аймгийн хатан Хар-Ус нуур дээр зохион байгуулагдлаа.<br>Тус арга хэмжээнд 12 ханатай гэр барьж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг танилцуулан, орон нутгийн онцлогийг харуулсан соёлын өвийн үзэсгэлэн, брэнд бүтээгдэхүүнүүдийг худалдаалж оролцлоо. Мөн Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын уран бүтээлчид Алтай ятга хөгжимтэй Алтайн магтаал, Жангар тууль хайлж, 30 минутын тоглолт бэлтгэн мэндчилгээ дэвшүүллээ. | 100 |
| **1.5. Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр** | | | | | | | |
| 1.5.1 | Хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх зорилготой "Түр хамгаалах байр"-г Япон улсын "Өвсний үндэс | Төсөөс, орон нутгийн төсөв | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Япон Улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хөрөнгөөр санхүүжигдэх "Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн барилгыг 696.9 сая төгрөгөөр гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчээр "Хүслэнт хүдэр" ХХК шалгарч, ажлын явц 95 хувьтай байна. Тус төвийг ашиглалтад ороход НҮБ-ын Хүүхдийн сангаас тоног төхөөрөмж, материалын дэмжлэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийн санхүүжилтээр барьж, байгуулан, үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэнэ. | | | | | үзүүлэхээр боллоо. | |
| 1.5.2 | Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг судлан тогтоож, хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, шаардлагатай тусламж үйлчилгээнд хамруулна. | УТ, ОНТ | Хамрагдсан хүүхдийн тоо | 420 | 420 | Хүүхдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр 16 ажлыг зохион байгуулж, 9851 хүн, 21250 хүүхдийг хамрууллаа. Эрсдэлт нөхцөл дэх 46 хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээнд холбон зуучлан үйлчилгээ үзүүлж байна. Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээнд 858 хүүхдийг хамруулж, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг 274 хүүхдэд үзүүллээ. Эрсдлийн программын шинэчлэл хийж, сумдын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтнүүдэд эрсдлийн программын талаарх мэдээллийг өгч, 635 хүүхэд бүртгэлтэй байгаагаас 359 эрэгтэй 276 эмэгтэй байна.<br>Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Хүүхдийн эрхийг дээдлье" уриан дор зохион байгуулагдсан баярыг угтан эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хамгааллын үйлчилгээ шаардлагатай 174 хүүхдийг төрийн 70 байгууллагын харъяалалд хариуцуулан өгч бэлэг өгөх, тусламж дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, цаашдаа тэдгээр хүүхдүүдийг хариуцан жилд 2 удаа баярлуулах, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах чиглэлийг өглөө.<br>"Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-г 16 сумд зохион байгуулж хамтарсан баг хүүхдийн төлөө зөвлөлийн өргөтгөсөн хурлыг хийж 4021 хүнийг хамрууллаа. Мөн 93 хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд холбон зуучиллалаа.<br>Зорилтот гэр бүлүүдэд тулгамдаж буй асуудлыг судалж, хэрэгцээт үйлчилгээнд холбох шаардлагатай тусламж дэмжлэгийг тодорхойлох, дэмжлэг, тусламж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзүүлэх зорилгоор Есөнбулаг сумын зорилтот 60 өрхийг судалгаанд хамрууллаа. Халамжийн үйлчилгээнд 1 иргэн, боловсролын үйлчилгээнд 1 сурагч, дэмжлэг туслалцаанд 3 иргэнийг хамрууллаа. Мөн 1 иргэнийг ХХҮГ-т холбон зуучилж гэр олголоо.<br>Хүүхдийн тусламжийн 108 утсанд 71 дуудлага ирж 54 дуудлагыг шийдвэрлэж 17 дуудлага хяналтад хамгааллын үйлчилгээ үзүүллээ. Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой 24 өргөдөл ирсэн бөгөөд 14 өргөдлийг шийдвэрлэж 10 өргөдлийг судалж байна.<br>ХЭХЗХ-д бүртгэлтэй 63 хүүхэд байгаагаас гэмт хэргийн сэжигтэн 18, хохирогч 18, зөрчил үйлдэж шийтгүүлсэн 10, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээгээр шийтгэгдсэн 20 хүүхэд байна. Эдгээр хүүхдүүдээс 54 хүүхдэд үйлчилгээ үзүүлэн урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 2,0 сая, өмгөөлөл эрх зүйн туслалцаанд 5,0 сая төгрөгийн төсвийг зарцуулсан. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжсэн 20 хүүхдэд Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Залуучуудын хөгжлийн төвтэй хамтран сургалт хүмүүжлийн ажлыг төлөвлөгөөний дагуу сар бүр зохион байгуулж байна.<br>Хүүхдийн эрхийн зөрчлийн 49-гомдлыг хүлээн авч 2 гомдолд зөрчил үүсгэн гомдол мэдээллийг хугацаанд нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэн зөрчил гаргагчид 800.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан бөгөөд шийдвэрлэлт 85,8%-тай байна.<br>Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр 52 хүүхэд, 46 насанд хүрэгч үйлчлүүлж, гэр бүлийн боловсрол олгох сургалтад 2466 хүн хамрагдлаа. Улаан загалмайн хорооны дэргэдэх "Түр хамгаалах байр"-ны үйл ажиллагаанд аймгийн ЗДТГазраас 30,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, тус төвд 11 эмэгтэй, 23 хүүхдийг байрлуулж үйлчилгээ үзүүллээ. Энэ онд Япон Улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хөтөлбөрийн хөрөнгөөр "Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг барьж байгаа ба барилгын ажлын явц 95%-тай байна. | |
| 1.5.3 | "Засагт ханы хот айл гэр зуслан"-г 8-аас доошгүй | ОНТ | Хамрагдсан хүүхдийн тоо | 275 | 300 | Аймгийн хүүхдийн зуслан нь стандартын шаардлага хангахгүй байгаа тул үйл ажиллагаа түр зогссон байна. Иймд хүүхдийг хөгжүүлэх, амралт чөлөөт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сумдад ажиллуулан, монгол ахуй, ёс заншил, амьдрах ухаанд суралцуулна. | | | | | цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газартай зөвшилцөн Баянхонгор аймгийн "Өвгөн жаргалант" хүүхдийн зуслантай гэрээ хийн, 178 хүүхдийг амрааж, зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хамрууллаа. Үүнээс бүтэн, хагас өнчин, тусгай хэрэгцээт 42 хүүхэд хамрагдлаа. "Засагт ханы хот айл" гэр зуслан ажиллуулах тухай чиглэлийг аймгийн Засаг даргын орлогчийн 2024 оны 2/737 тоот албан бичгээр сумдад хүргүүллээ. Сумуудаас Цогт, Баян-Уул сумууд зуслангийн үйл ажиллагаа явуулж, 245 хүүхдийг хүлээн авч аюулгүй байдлыг нь ханган, тав тухтай амраахын зэрэгцээ өөрийнх нь авьяасыг хөгжүүлэх сонгон суралцах болон бусад сургалтуудыг зохион байгууллаа. | |
| 1.5.4 | Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг олгож, хамтран ажиллана. | ОНТ | Хамтран ажилласан ТББ-ын тоо | 5 | 5 | Аймгийн Засаг даргын Тамгын газар ахмадын хороотой гэрээ байгуулан ахмад настнуудад мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, хүндэтгэлийн болон нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, орон нутгийн төсвөөс 164.6 сая төгрөгийн санхүүжилт олгон, үйл ажиллагааг байнга дэмжин ажиллаж байна. Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих зорилгоор сум, тосгоны ахмадын хорооны үйл ажиллагаанд 50,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.<br>Аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн "Олон улсын гэр бүлийн өдөр"-өөр зохион байгуулсан "Хамгийн дулаахан газар" гэр бүлийн зөвлөгөөний үйл ажиллагаанд 4,5 сая, үндэсний бөхийн холбоонд 2,0 сая, хөлбөмбөгийн холбоонд 4,0 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүллээ.<br>Мөн аймгийн Улаан загалмайн хорооны түр хамгаалах байрны үйл ажиллагаанд 30,0 сая төгрөгийн санхүүжилт олголоо. "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголын эмэгтэйчүүдийн холбооны сумдын эрүүл мэндийн төвийн төрөх, үзлэгийн орыг солих ажилд 16,0 сая, "Ухаалаг хөгжил" академитай гэрээг байгуулан эрүүл мэндийн сургалт сурталчилгааг зохион байгуулахад 10,0 сая, "Бат гэрэлт гүүр" ТББ-аас аймгийн төрийн албан хаагчдад "Стрессийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түвшингээ тодорхойлох, стрэсс үүсэх шалтгаан, эерэг ба сөрөг стресс, "Хандлага сэтгэл зүйд нөлөөлөх нь" сэдэвт сургалт зохион байгуулж, ажлын байрны иог дасгал хөдөлгөөн заах, стресс харилцаа хандлагыг тусгай тестийн дагуу үнэлэхэд 10,0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүллээ. | |
| 1.6.Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр | | | | | | | |
| 1.6.1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилгүй иргэдийн судалгаар сумаар гарган, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх талаар оновчтой арга хэмжээ зохион байгуулж ажиллах, өрх бүрт ажлын байр бий болгох талаар дэмжиж ажиллана. | УТ, ОНТ | Ажлын байрны тоо | 1372 | 1372 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд уулзалт, өдөрлөг, хэлэлцүүлгийг зорилтот бүлэг бүрээр зохион байгуулж, ажил олгогчдын талаарх мэдээллийг өгч ажилласнаар байнгын 973, улирлын 124, түр 278 нийт 1375 шинэ ажлын байрыг бий болголоо.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн дэмжлэг олгох замаар ажлын байр бий болгох арга хэмжээний хүрээнд арилжааны банкуудтай хамтран жилийн 6% хүүтэй, 36 сарын хугацаатай зээлийг олгож, Хаан банк 28 ААН, иргэнд 875,0 сая төгрөг, Төрийн банк-6 иргэнд 225,0 сая төгрөг, нийт 34 ААН, иргэнд 1,1 тэрбум төгрөгийг олголоо.<br>Тайлант онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, нийтлэг үйлчилгээнд 3976 иргэнийг хамруулж 2279.6 сая төгрөг зарцуулахаас 4037 иргэнийг хамруулж 2117.9 сая төгрөгийг зарцуулж, хэрэгжилт 100.9 хувьтай байна. Үүнд:<br>-Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 2352 иргэн хамрагдаж, 957 иргэн ажлын байраар хангагдаж, 18.3 сая төгрөг<br>-Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд 770 иргэн хамрагдаж, 39.4 сая төгрөг<br>-Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 220 иргэн хамрагдаж, 206 иргэн ажлын байраар хангагдаж, 1697.2 сая төгрөг<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 226 иргэн хамрагдаж, 27 иргэн ажлын байраар хангагдаж, 177.0 сая төгрөг<br>-Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд 469 иргэн хамрагдаж, 467 иргэн ажлын байраар хангагдаж 185.9 сая төгрөгийг тус тус зарцууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийт 1551 ажлын байрны захиалга ирүүлсний дагуу ажилгүй 878 иргэнийг ажилд зуучиллаа. | |
| 1.6.2 | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, орон нутгийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | УТ | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн зөвлөл нь 4 удаа хуралдаж тухайн онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, гишүүдийн чиг үүргийг батлахаас гадна тайлант онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, 2024 оны ХЭДСангийн төсөвтэй танилцаж, санал солилцлоо. Мөн 2023 оны Аудитын хяналт шалгалтын дүгнэлттэй танилцаж үүрэг чиглэлийг өгч 2024 оны санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар хүсэлт ирүүлсэн иргэдийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хамтран зохион байгууллаа. Мөн хурлаар хагас, бүтэн жилийн тайлан мэдээг хэлэлцэж, зөвлөлийн 2 гишүүн ажлын хэсэгт орж, төслөө ирүүлсэн 30 гаруй иргэний ажлын байртай танилцаж, шийдвэр гаргалаа. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих, шилдэг санааг шалгаруулах "Старт-ап" арга хэмжээний шалгаруулах ажлын хэсэгт орж ажиллалаа. Үүнд: 18-34 насны залуучуудын 30 баг бүртгүүлж 54 цагийн сургалт арга хэмжээнд хамрагдлаа. Дээрх сургалтын үеэр багуудад зөвлөх ментор багш ажиллаж эцсийн сонгон шалгаруулалтад 5 баг үлдсэнээс уламжлалт аргаар адууны арьсан хавтага хийх Н.Дэлгэрзаяа ахлагчтай "Хийморь" баг шалгарч, эргэн төлөгдөх нөхцөлгүй 10,0 сая төгрөгийн дэмжлэгийг ХЭДСангаас олголоо. Мөн тус зөвлөл нь "Хөдөлмөрийн харилцаан дахь хүний эрх" сэдэвт уралдаант дэвжээ тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулийн 11-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. | 100 |
| 1.6.3 | ХАБЭА-н зөвлөлийг тогтмол хуралдуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэн ажиллана. | УТ, ОНТ | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон нутгийн зөвлөлийн 2024 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гишүүдээс санал авч боловсруулан батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг "Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе" уриан дор зохион байгуулахаар постерыг гаргаж, аяны нээлтэд аймгийн ЗДТГ-ын удирдлагууд, сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дарга нар, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аж ахуйн нэгж байгууллагын ХАБЭА ажилтан нийт 85 орчим хүн оролцлоо. "Алтай-Улиастай" эрчим хүчний систем дээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг сурталчлах ажил мэргэжлийн 8 багийн уралдаан зохион байгуулагдлаа.<br>Байгууллагуудын хамтарсан сургалтыг Тайшир сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа "Цэнгазар" ХХК-ийн төслийн талбайд ажиллаж байгаа "Макс-Өргөө" ХХК-ийн нийт 185 ажилтан, албан хаагч нарыг хамруулан "Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийг даван туулах, арга зам, аюулгүй ажиллагаа, анхны тусламж" сэдвүүдээр танхимын болон практик, дадлага сургалтуудыг хослон зохион байгууллаа.<br>Аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулиудын 11-12 дугаар ангийн 30 сурагчийг оролцуулан "Уул уурхайн мэргэжлээ крашлая" 1 өдрийн арга хэмжээг "Хан-Алтай ресурс" ХХК-ийн төслийн талбайд зохион байгууллаа.<br>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 25 аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах 2 цагийн багц сургалтыг "Эрсдэлийн удирдлага, аюул эрсдэлийг илрүүлж арилгах" сэдвээр "Хан-Алтай ресурс" ХХК-тай хамтран зохион байгуулж, танхимаар 28, онлайнаар 16 нийт 44 ажилтан хамрагдлаа.<br>Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байгаа "Зорь бүтээ" ХХК-тай хамтран МСҮТ-ийн 30 оюутанд цахилгаан люлк ажиллуулах үеийн аюулгүй ажиллагаа, өндрийн ажил болон шат тавцан дээр ажиллах аюулгүй ажиллагаагаа сэдвүүдээр үзүүлэх сургалт хийж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн мэдлэг олгох практик ажлыг зохион байгуулав.<br>Сарын аяны постер бэлтгэн сургалт мэдээллийн ажлын үед олон нийтэд цацаж, хөдөлмөрийн аюулгүй байдлын хуулийн заалт, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, гамшгийн үед аюулгүй байдлын хангах нь зэрэг 3 төрлийн гарын авлага бэлтгэн, сургалт, мэдээлэл авсан иргэдэд 450 ширхгийг тараав. Аяны талаар 6 удаагийн мэдээ, мэдээллийг бэлтгэн орон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сум, байгууллагуудын цахим хуудсаар олон нийтэд сурталчилж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл авахаар ирсэн 14 иргэнд холбогдох асуудлын хүрээнд эрх зүйн зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа.ХАБЭА-н улсын үзлэгийг сарын хугацаанд зохион байгуулж, 143 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, 109 шалгуур үзүүлэлтээр байгууллага бүрийг дүгнэж, заавар зөвлөгөө өглөө. | |
| 1.6.4 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. | УТ | Төсөл, хөтөлбөрт хамрагдсан хүмүүсийн тоо | 1134 | 1400 | Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны хүрээнд 25 ба түүнээс дээш хөдөлмөрийн насны хувиараа хөдөлмөр эрхлэгч 57 иргэнд 570.0 сая төгрөгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатай олголоо. Мөн арилжааны банкуудтай хамтран жилийн 6% хүүтэй, 36 сарын хугацаатай зээлийг олгож, Хаан банк 28 ААН, иргэнд 875.0 сая төгрөг, Төрийн банк-6 иргэнд 225.0 сая төгрөг, нийт 34 ААН, иргэнд 1,1 тэрбум төгрөгийг олголоо. Зорилтот бүлгийн 6 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 5 аж ахуйн нэгжид 39.6 сая төгрөгийн ажил олгогчийн урамшуулал олгосноос гадна зорилтот бүлгийн 9 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 8 байгууллагад ажил олгогчийн урамшуулал олгохоор гэрээ байгууллаа. Малжуулах арга хэмжээнд 18-аас дээш насны 2-оос доошгүй гишүүнтэй 16 сумын 85 малчин өрх хамрагдаж ХЭДСангаас 680.0 сая төгрөгийн 10253 толгой малаар малжууллаа.Хувиараа хөдөлмөр эрхлэгч 48 ахмадад 384.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 24 сарын хугацаатай хүүгүй олголоо. Ахмадын зөвлөх үйлчилгээний хүрээнд 22 ахмадтай гэрээ хийж, ерөнхий боловсролын сургуулийн дугуйлан секцид хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн авъяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх зорилгоор соёл урлаг, спорт, боловсрол чиглэлээр сургалт, дугуйлан зохион байгуулж, 23,7 сая төгрөгийн урамшуулал олголоо. Энэ зөвлөх үйлчилгээнд 595 хүүхэд, 408 иргэн нийт 1003 хамрагдлаа. Үүнээс гадна тэтгэвэрт гарсан 2 ахмадыг "Хүүхэд хамгаалагч"-аар ажиллуулж, ХЭДСангаас 2.6 сая төгрөгийн урамшууллыг олгож, 1800 гаруй хүүхдэд лоо. Хөгжлийн бэрхшээлтэй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч байгаа 27 иргэнд 160.0 сая төгрөгийн дэмжлэгийг олгож, гар урлалын сургалтад 12 иргэнийг хамрууллаа.<br>Мод тарих, нийтийг хамарсан ажилд 445 иргэнийг хамруулж, ХЭДСангаас 159,5 сая төгрөгийг зарцуулж, түр ажлын байраар ханган орлогын дэмжлэг үзүүллээ. Ажилгүй иргэдийн эрэлт хэрэгцээнд үндэслэн эрх бүхий "Футур" сургалтын төвтэй хамтран ажилгүй 22 эмэгтэйг оёдол, эсгүүрчний мэргэжил олгох сургалтад хамруулж, ХЭДСангаас 3.9 сая төгрөгийг зарцууллаа. Энэ онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, нийтлэг үйлчилгээнд 4037 иргэнийг хамруулж 2117.9 сая төгрөгийг зарцууллаа. | |
| | 1.7. Нийгмийн хамгааллын чиглэлээр | | | | | | |
| 1.7. 1 | Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллана. | УТ, ОНТ | Хамрагдсан иргэний тоо | 32111 | 32111 | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байсан 7 өрх ажилтай орлоготой болж өрхийн амьжиргаа дээшилсэн тул үйлчилгээнээс хасагдсан.<br>Халамжийн сангаас Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 3 бүлэгт 9000,0 мянган төгрөгийн буцалтгүй дэмжлэг олголоо.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас иргэнд олгох санхүүгийн дэмжлэг 3 иргэнд 30000,0 мян.төг, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 1 ахмадад 8000,0 мян.төг, малжуулах хөтөлбөрт 4 өрхийн 8 иргэн хамрагдаж 32000,0 мян.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэгт 3 иргэн хамрагдаж 22000,0 мянган төгрөгийг 50%-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр тус тус олгож нийт 15 иргэнд 92000,0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгов.<br>Нийтийг хамарсан ажилд 44 иргэн хамрагдан 15840,0 мянган төгрөгийн ажлын хөлс авч өрхийн орлогоо нэмэгдүүллээ. Зорилтот бүлгийн ажилгүй иргэдээс байнгын ажлын байранд 7, түр ажлын байранд 3, туслах малчнаар 4 иргэнийг ажилд зуучиллаа.<br>Аж ахуй эрхлэлтийн сургалтад 17, хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын сургалтад 22, зээлийн өмнөх сургалтад 11, ОНОТХҮ-ний гар урлалын сургалтад 9, | 100 |

(5) (6) (7)

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүлэмжийн аж ахуй эрхлэх сургалтад 13, хулсан болон давсан урлалын сургалтад 6 иргэн тус тус хамрагдлаа.<br>Зорилтот бүлгийн иргэдийг гэр оронтой болгох зорилго бүхий "Дэм дэмэндээ-20" сайн үйлсийн аяны дэвтэр, тугийг байгууллагуудаар аялуулж, 18 сум 2 тосгоны 95 ААНБ, 1782 иргэн нэгдэж 31.3 сая төгрөг хандивлаж, 8 айл өрхийг гэр оронтой болголоо. | |
| 1.7.2 | Ахмад настны хөгжил оролцоог дэмжиж нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамруулж, аймаг, сумдын ахмадын хорооны үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг олгож хамтран ажиллана. | ОНТ | Санхүүгийн дэмжлэг /сая төг/ | 106,6 | 187,3 | Аймгийн ахмадын хороотой гэрээ байгуулан ахмад настнуудад мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, хүндэтгэлийн болон нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, орон нутгийн төсвөөс 164,6 сая төгрөгийн санхүүжилт олгон, үйл ажиллагааг байнга дэмжин ажиллалаа. Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих зорилгоор сум, тосгоны ахмадын хорооны үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын 2024 оны А/133 дугаар захирамжаар 50,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ.<br>Аймгийн Ахмадын хорооноос зохион байгуулсан сумуудын ахмадын хорооны дарга нарын арга зүйн сургалт зөвлөгөөнд Аймгийн Засаг дарга, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга нар оролцож, төр засгаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн талаар мэдээлэл өглөө. Аймагт улсын төсвөөр Ахмадын сувилал баригдаж байгаа ба барилгын явцын ажил 50%-тай байна.<br>Сар шинийн баяраар аймгийн 90-аас дээш ахмад настан 64 хүнд аймгийн Засаг даргын гарын бэлгийг гардуулж өглөө. Мөн улс тунхагласны баяраар Есөнбулаг сумын 90-ээс дээш настай 24 хүнд гарын бэлэг өглөө. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас харьяалалгүй ахмадуудад ахмадын баяр болон цагаан сараар бэлэг өгч хэвшсэн ба давхардсан тоогоор 5100 гаруй ахмад хамрагддаг. Ахмадуудад 7 хоногт 2 удаа биеийн тамирын заалыг үнэ төлбөргүй ашиглуулж байна. Аймгийн төвд нийтийн тээврийн 2 автобусаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдүүд үнэ төлбөргүй үйлчлүүлж байна. Угийн бичиг, гэр бүлийн боловсрол олгох 7 удаагийн сургалтад 175 ахмад хамрагдлаа. Есөнбулаг сумын 1700 гаруй ахмад настанд 200кг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нүүрсний дэмжлэг олголоо. Баянхонгор аймагт зохион байгуулагдсан "Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх нь" хангайн бүсийн сургалт, зөвлөгөөнд 7 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, замын зардлыг аймгийн ЗДТГ-аас шийдвэрлэж өглөө. | |
| 1.7.3 | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн сургалт, сурталчилгааг өргөжүүлж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | УТ | Хүний тоо | 3912 | 3950 | Нийгмийн даатгалын багц хууль тогтоомж, нийгмийн даатгалын ач холбогдлыг танин мэдүүлэх, явуулын үйлчилгээ үзүүлэх, иргэд даатгуулагч, малчдыг хамруулах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр 71 удаа, 205 удаагийн уулзалт, сургалтанд 27880 даатгуулагч иргэд хамрагдлаа. Үүний үр дүнд албан журмын даатгалд 10159 иргэн, сайн дурын даатгалд 2980 малчин, 820 хувиараа хөдөлмөр эрхлэгч нийт 3800 сайн дурын даатгуулагч хамрагдлаа. | 100 |
| | 1.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр | | | | | | |
| 1.8. 1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчийн асаргаа, сувилгааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг энэ чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. | УТ, ОНТ | Хамрагдсан хүний тоо | - | 500 | Хүний эрхийн үндэсний комиссын Говь-Алтай аймгийн референт, "Ээлтэй хүүхэд" ТББ-н тэргүүлэгч нартай хамтран Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 3 сургууль, 2 цэцэрлэгийн албан хаагчдад хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрх" болон хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн хүрээнд нийгмийн халамжийн сангаас олгогддог тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн талаар мэдээлэл хийлээ. Мөн манай аймагт "Жайка стар-2" төслийн баг ажилласантай холбогдуулан сургууль, цэцэрлэгийн тусгай хэрэгцээт хүүхдийн "Хүүхэд хөгжлийн төв"-ийн үйл ажиллагаатай танилцан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн ажиллалаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй орчин" сэдвийн хүрээнд хүний хүртээмжтэй орчин бүрдүүлэхэд талуудын оролцоо, тулгамдсан асуудал, шийдлийн талаарх хэлэлцүүлгийг аймаг дахь хүний эрхийн комиссын референт болон төрийн байгууллагуудын төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэний холбооны төлөөлөл нийт 25 хүн оролцож зохион байгуулж тулгамдсан асуудлуудаа хэлэлцэж | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохих шийдвэр гаргалаа. Улаан загалмайн хороотой хамтран "Жендэрийн тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо" хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулж, орон нутагт тулгамдаж буй асуудлууд, гарц шийдэл, сайн туршлагаа хуваалцлаа. | |
| 1.8.2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөвт тусгах, албан байраар болон гишүүдийн ажиллах нөхцлийг хангаж, тайланг жил бүр хэлэлцэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах зэрэг шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлж ажиллана. | УТ, ОНТ | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 16 удаа хуралдаж 183 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргалаа. Үүнд: шинээр хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоолгосон 51 хүүхэд, шинээр байнгын асаргаанд байх шаардлагатайг тогтоолгосон 29 хүүхэд, байнгын асаргааны хугацааг сунгуулсан 97 хүүхэд байна.<br><br>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 208, боловсролын үйлчилгээнд 146, боловсролын бусад үйлчилгээнд 30 хүүхдийг хамруулах шийдвэр гарган холбон зуучилж, хяналт тавьж ажилласан.<br><br>Дээрх хүүхдүүдийг нийгмийн халамжийн сангаас олгодог тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид тухай бүр хамрууллаа. | 100 |
| 1.8.3 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг саадгүй, | УТ, ОНТ | Хэрэгжилтийн хувь | - | 90 | Аймгийн ЗДТГ болон төрийн байгууллагуудын цахим хуудсаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг хүргэн ажиллаж байна. Тус аймгийн орон нутгийн "Алтай" телевиз, "Миний нутаг" сошиал телевиз, олон нийтийн "Алтай" радио, "Монцамэ-Говь-Алтай" сайт | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртээмжтэй авах нөхцөл боломжийг бүрдүүлж, иргэдийн хамгийн их ашигладаг болон аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсуудын хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулан, орон нутгийн телевизийн хөтөлбөрийг хадмал орчуулагчтайгаар гаргах, хөгжлийн бэрхшээлийн асуудлаар нийгэмд чиглэсэн мэдээ мэдээлэл, хуулийн хэрэгжилтийг сурталчлахад анхаарч үнэ төлбөргүй түгээнэ. | | | | | болон "Алтайн мэдээ агентлаг" пейж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээ мэдээлэл болон хуулийн хэрэгжилтийг хүргэж байна. Мөн гарын авлага, материал бэлтгэн хүргэж байна. | |
| | ХОЁР. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | |
| 2.1.1 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратегийг хэрэгжүүлж ажиллана. | УТ, ОНТ | Хэрэгжилтийн хувь | 90 | 90 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратегийг хэрэгжүүлэх 31 заалт бүхий төлөвлөгөөг жендэрийн салбар хороогоор хэлэлцүүлэн аймгийн Засаг даргаар батлуулж, сум байгууллагуудад хүргүүллээ.<br>Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр 52 хүүхэд, 46 насанд хүрэгч үйлчлүүлж, гэр бүлийн боловсрол олгох сургалтад 2466 хүн хамрагдлаа. Улаан загалмайн хорооны дэргэдэх "Түр хамгаалах байр"-ны үйл ажиллагаанд аймгийн ЗДТГазраас 30,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, тус төвд 11 эмэгтэй, 23 хүүхдийг байрлуулж үйлчилгээ үзүүллээ. Энэ онд Япон Улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хөрөнгөөр "Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах нэг | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэгийн үйлчилгээний төв"-ийг барьж байгаа ба барилгыг 696.9 сая төгрөгөөр гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчээр "Хүслэнт хүдэр" ХХК шалгарч, ажлын явц 95%-тай байна.<br>Гэр бүлийн болон хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын 30 хамтарсан баг Есөнбулаг сумын 6 сургуульд хариу үйлчилгээний зардалд 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн арга зүйгээр хангаж ажиллалаа. Тус хамтарсан багууд нь гэр бүлийн хүчирхийллийн 77 зөрчил, дуудлага мэдээллийг хүлээн авч, 25 кейсийг хааж, 52 кейс дээр ажиллаж, дараах үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Үүнд: Аюулгүй байдлыг хангах үйлчилгээг 21, эмнэлгийн тусламж үйлчилгээг 12, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг 140, эрх зүйн туслалцааг 26, нийгмийн халамжийн үйлчилгээг 25, дэмжих холбон зуучлах үйлчилгээг 69 иргэнд, хүүхэд хамгааллын үйлчилгээг 54 хүүхдэд тус тус үзүүллээ.<br>Мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 83 сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж 3735 иргэнийг хамрууллаа. Аймгийн Цагдаагийн газартай хамтран зохион байгуулдаг авто тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон болон гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэн саатуулагдсан 119 иргэнд /давхардсан тоогоор/ зан үйлд нөлөөлөх 34 удаагийн сургалтыг зохион байгууллаа.<br>Улаан загалмайн хороотой хамтран "Жендэрийн тэгш байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо" хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулж, орон нутагт тулгамдаж буй асуудлууд, гарц шийдэл, сайн туршлагаа хуваалцаж, тус хэлэлцүүлэгт оролцсон иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудад "Хамгаалал, жендэр, оролцоо"-ны талаар чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа. Өсвөр үеийхэнд Жендэрийн хэвшмэл буруу ойлголтоос ангид байх, жендэрийн мэдрэмжтэй иргэн болон төлөвшүүлэх, цахим орчин дахь ялгаварлан гадуурхалтыг багасгах чиглэлийн сургалтад 412 хүүхдийг хамруулж, "Хамгийн дулаахан газар" арга хэмжээний хүрээнд гэр бүлийн зөвлөгөөнд оролцсон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 150 өрхөд "Жендэр ба гэр бүл", төрийн байгууллагын 200 албан хаагчдад сэтгэл зүй, гэр бүлийн боловсролын талаар мэдээлэл өгч, "Амьдралыг хамтдаа урлая" сургалтад 52 хосыг хамрууллаа. "Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал" үндэсний чуулганд НБХ-ийн дарга, Ховд аймагт зохион байгуулагдсан "Тогтвортой хөгжилд эмэгтэйчүүдийн манлайлал" үндэсний форумд аймгаас 10 эмэгтэй тус тус оролцлоо. Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох чиглэлээр нийт 10 гаруй байгууллага хүүхдийн өрөө, номын сан тохижуулан гэр бүл, хүүхдэд ээлтэй байдлыг бий болголоо. Хүүхдийг үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Дахин бүү гэмтээ" сургалтыг Мэргэжлийн боловсролын сургуулийн дотуур байрны 130 сурагчдад дасгал, тоглоом, бие даан гүйцэтгэх даалгавар өгөх, багаар ажиллах зэрэг оролцооны аргуудыг ашиглан зохион байгууллаа. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд төр, төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийт нэгдэж, гэр бүлийн болон охид, эмэгтэйчүүдийг эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл өгч, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгууллаа. | |
| 2.1.2 | Аймгийн Засаг даргын салбарын сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж, сумын Засаг дарга нартай байгуулсан гэрээний нийгмийн салбарын зорилтуудын хэрэгжилтэд хяналт тавина. | УТ, ОНТ | Хэрэгжилтийн хувь | 90 | 90 | Аймгийн Засаг даргын салбарын сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийн эхний хагас болон жилийн эцсийн биелэлтийг ХШҮХэлтсээр хянуулж, хугацаанд нь хүргүүллээ. | 100 |
| | **ГУРАВ. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | |
| 3.1 Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангах | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1 | Төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан ажиллаж, удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлүүлнэ. | - | Хугацаанд нь биелүүлсэн ажлын тоо | Хугацаанд нь | Хугацаанд нь | Удирдлагаас өгсөн болон мэргэжилтнүүдийн санаачилгаар 120 захирамж гаргаж, хэрэгжүүлж ажиллалаа. Яам, бусад байгууллагаас ирсэн 170 бичгийг хугацаанд нь шийдвэрлэж хүргүүллээ. Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, хэлтэст ирсэн 55 өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, албан бичгээр хариуг өглөө. | 100 |
| 3.1.2 | Хэлтсийн 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт хүлээлгэж өгнө. | - | Хадгаламжийн нэгжийн тоо | 8 | 8 | Боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, жендэр, төрийн бус байгууллагын чиглэлээр 11 архивын нэгж бүрдүүлж, хүлээлгэн өглөө. | 100 |
| 3.1.3 | Байгууллага дээр зохион байгуулагдах сарын ажлыг хуваарийн дагуу зохион байгуулна. | - | Төлөвлөгөө | 1 | 1 | Тус хэлтэс нь 02 дугаар сарыг хариуцан ажиллаж, 10 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжүүллээ. Үүнд: АЗДТГ-ын албан хаагчдын цагаан сарын золголтыг зохион байгуулж, "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй "Аяганы соёл" арга хэмжээнд нэгдлээ. "Монголын гайхамшигт өв соёл" танин мэдэхүйн уралдаант тэмцээнийг байгууллагуудын залуу төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж, байгууллагаа төлөөлж ТЗУХ-ийн бичиг хэргийн эрхлэгч Зээрээ оролцлоо.<br>Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх зорилгоор 4 удаагийн чөлөөт тоглолт, буухиа тэмцээнийг зохион байгуулж, шагналаа. Байгууллагын ажилтан, албан хаагчдыг хуримтлалтай болгох зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 16-ны өглөө 08.30 цагт "Мөнгөний үнэ цэнэ" санхүүгийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж; 25 албан хаагч оролцлоо. Мөн шинээр гарсан олон сайхан номноос худалдан авч, оюуны хөрөнгө оруулалт хийлээ. Албан хаагчдын дунд "Караоке" тэмцээн, монгол бичгийн цэвэр бичигтэн зэрэг уралдаан тэмцээн зохион байгуулж, шагнаж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урамшууллаа.<br>2024 оны 2 дугаар сард төрсөн 9 албан хаагчид төрсөн өдрийн бэлэг өглөө.<br>Хүүхдийн өрөөний үйл ажиллагааг хариуцаж, камержуулан, цоожыг нь солилоо.<br>ТЗУХ-тэй, хамтран албан хаагчдын танилцуулга бүхий самбарыг шинэчлэлээ. Зохион байгуулсан үйл ажиллагааг нэгтгэн танилцуулга бэлдэж хэлтсийн даргад өгч, албан хаагчдын хуралд танилцууллаа. | |
| 3.1.4 | Албан тушаалтны 2023 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж, тайлагнана. | - | Мэдүүлэг гаргах албан хаагчийн тоо | 2 | 2 | Албан тушаалтны 2023 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хэлтсийн дарга болон ахлах мэргэжилтэн 2024 оны 02 дугаар сарын 15-наас өмнө гаргаж программд оруулан баталгаажууллаа. | 100 |
| | ДӨРӨВ. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ | | | | | | |
| 4.1. | Харьяа агентлагуудын үйл ажиллагаатай танилцах, зөвлөн туслах, мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах ажлыг тогтмолжуулж ажиллана. | - | Зөвлөн тусалсан байгууллагын тоо | 7 | 7 | Хэлтсийн дарга болон мэргэжилтнүүд салбарын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, тайлан мэдээ гаргах болон бусад асуудлаар санал солилцож, заавар, зөвлөгөө өглөө. | 100 |
| 4.2 | Сумын ЗДТГ-н үйл ажиллагаанд зөвлөн туслах, сургалт зохион байгуулах | - | Зөвлөн тусалсан сумын тоо | 3 | 3 | Сумдын удирдлагуудын сургалт, уулзалтад хэлтсийн дарга оролцож, нийгмийн салбарын талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл өглөө. | 100 |
| 4.3 | Аймгийн Засаг даргаас сум, Агентлагын удирдлагуудтай байгуулсан гэрээнд тусгасан заалтуудыг | - | Зөвлөмж, чиглэлийн тоо | - | 4 | Аймгийн Засаг даргаас сум, агентлагын удирдлагуудтай байгуулсан гэрээнд тусгасан заалтуудыг хэрэгжүүлэх ажилд хяналт тавин ажиллаж, заавар зөвлөгөө өглөө.<br>Агентлагын дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1-4-р улирлын тайланг дүгнэж үнэлэн ТЗУХ-т өглөө. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх ажилд хяналт тавьж, чиглэл зөвлөмж өгч ажиллах | | | | | | |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

Аймгийн ЗДТГ-ын дарга ........................................ /Ш.Эрдэнэбат/

2024.12.10

*Тайлагнасан:* **Нэгжийн дарга**

НБХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................................ /Ж.Амгаланбаатар/

2024.12.09